

УУЛБАЯН СУМЫН ХАГАС ЖИЛИЙН МЭДЭЭ

2024-6-30

Зүүнбулаг

Удирдлагын чиглэлээр:

Төрийн албан хаагчдын хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, үнэлгээний хуудсыг олгож, хувийн хэрэгт хавсаргах ажлыг зохион байгуулав.

Улсын Их Хурлын сонгуулийн ажлыг зохион байгуулах Сонгуулийн салбар, хэсгийн хороодын үйл ажиллагааг бэлтгэж, амжилттай зохион байгуулсан.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Баясгалант талбайд “ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах болсонтой холбогдуулан төв замын уулзварын авто замын хөдөлгөөнийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 08:00 - 17:00 хүртэл түр хугацаагаар хязгаарлах ажлыг зохион байгууллаа.

Бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг цахимаар тайлагналаа.

Байгаль орчны чиглэлээр:

Сумын засаг даргын А/57 дугаар захирамжийн дагуу Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулав. Сумын бүх иргэд, АНН-үүдийг хамруулан сумын төвийг 2 км-ийн радиуст бүрэн цэвэрлэгээ хийв.

Нэгдсэн хогийн цэгт үүссэн хог хаягдлыг цэгцлэх ажлыг зохион байгуулав. 5-н багийн хэмжээнд сэг зэм цуглуулах 17-н цэг тогтоож Сумын засаг даргын А/37 дугаар захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг уг ажлыг хийж гүйцэтгэв. Нийт 62341 малын сэг зэгийг цуглуулан булшлах, халдваргүйтгэх ажлыг зохион байгуулав. Нийт хоргодсон малын 91%-г булшлаад байна.

Сумын төвд ундны усны зориулалтаар хэрэглэдэг 5-н худгаас дээж авч Стандарт хэмжилзүйн газрын лабораторид өөрийн биеэр хүргэн өгч хариуг цахимаар авав. Хариу нь хэвийн гарав.

Хаврын мод тарих аяны хүрээнд мод үржүүлгийн газарт шинээр хайлаас 1080 ш, нарс 108 ш –г тарих ажлыг зохион байгуулав. Аяны хүрээнд иргэд 650 ш хайлаас модыг өөрийн эзэмшлийн хашаанд тарив. Сумын төвийн бүх ногоон байгууламжид /19 га/ тарьсан 60.0000 модонд цэнэг усалгаа хийх, арчилгаа хийх ажлыг зохион байгуулав.

Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ хоршоо чинээлэг малчин” аяныг хэрэгжүүлэх хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний бүсийн нээлтийн арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Дорнод аймагт зохион байгуулагдсан. Үүнд Сумын Засаг даргын Орлогч, малчны төлөөлөл-5 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.



2024 оны 05 сарын 11нд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, нар “Шинэ хоршоо хөдөлгөөний нээлтийн талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэлээ. Нийт 50 иргэн хамрагдлаа.



өгөх цахим сургалтад сумаас нийт 15 иргэн хамрагдсан.



алны амьтны дээт ирж хүнийн хамар аюулгүй сандан, Органик бүтээгдэхүүн түүхий баталгаажуулалт, Мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний талаарх мэдээ мэдээллийг, суманд жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй үйлдвэрлэгч, нийт 25 иргэнд сургалт өгч ажилласан. Мөн зоогийн газар, сургууль, 2 хүнсний дэлгүүрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явууллаа.



“Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд” иргэдэд мэдээ мэдээлэл өгөх зорилготой сургагч багш нар сумдад ажиллаж эхэлсэн манай суманд 2024 оны 05 сарын 19-нд ирсэн. 05 сарын 27-ны байдлаар улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлж, гэрчилгээ авч шинээр 6 хоршоо байгуулагдсан. Үүнд: Жонжтой айраг хоршоо, Шарга морьт дэлгэр хаан хоршоо, Өөдлөн дэвжих тэгш мандах хоршоо, Тэгш талын ургац хоршоо, Сэр гал мөнх хоршоо, Ээрэм талын мөнх хоршоо нар байна. Нийт 5 багийн 220 өрхөд мэдээлэл өгч ажилласан байна. Төсөл бэлэн болж Банкинд зээл судлагдаж байгаа 4 хоршоо байна.



Сумын засаг даргын А/55 дугаар захирамжаар “Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 аж ахуйн нэгжид олголоо.



Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

д/д	Шинээр төрсөн	Нас барсан	Эцэг, эх тогтоосон	Гэрлэсэн	И/Үнэмлэх 16 шинэ авсан	25, 45 сунгалт	Ши/хөдөлгөөн			И/Ү-ийн лавлагаа авсан	ТөлГэр дахин авсан
							Аймаг нийслэл ээс	Сум, дүүргээс	Баг, хороонд		
1	19 /эр-8/	4 /эр-1/	2/эр-1/	2	6 /эр-6/	17 /эр-10/	-	-	-	70	2

д/д	Хуулийн этгээд	Тоон гарын үсэг олголт			
	Шинээр байгуулагдсан хоршоо	Нийт	Иргэний үнэмлэхээр	Утасны аппаар	Эр
1	9	352	248	104	173

Мал эмнэлгийн чиглэлээр: 2024 оны 06 сарын 13-нд Хувийн хэвшлийн 4 мал эмнэлгийн малын эмч нар, сумын Засаг даргын гурвалсан гэрээг байгуулж баталгаажуулсан. Энэ үеэр малын эмч нарын зүгээс гаргасан мал эмнэлгийн үйлчилгээ явуулахад тулгардаг саад бэрхшээлийн талаарх санал бодлоо солилцож, цаашид сумын Засаг даргын зүгээс хууль тогтоомжийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээнд дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний үүргээ хэрэгжүүлэн ажиллахаар болсон.

Мал амьтны сэг зэмийг цуглуулж булж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн арга хэмжээ зохион байгуулах тухай сумын Засаг даргын 2024 оны 03 сарын 26-ны өдрийн А/37 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг сумын хэмжээний 13 устгалын цэгт мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллаа. Халдваргүйтгэлийн арга хэмжээг тухайн багийн малын эмч, мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч 1-2 туслах ажилтны хамт хийж гүйцэтгэсэн бөгөөд халдваргүйтгэлд хлорын шохой, хан кон, хайкоф, суфер килл зэрэг эм бэлдмэл, мотопомп, шүршигч, автомакс зэрэг тоног төхөөрөмжийг ашиглан зохион байгуулсан. Халдваргүйтгэлийн арга хэмжээний тайлан мэдээг аймгийн Мал эмнэлгийн газарт 05 сарын 14-нд хүргүүлсэн. Мал амьтны сэг зэм устгах халдваргүйтгэлийн арга хэмжээ 91,6% тай хангагдаж нийт 28,5 сая төгрөгийн зардал гарсан.

2024 оны 05 сарын 17,18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Орон нутгийн Мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагаа, чадавхийг сайжруулах” сэдэвт сургалтад тархвар зүйчийн хамт оролцож, 1 кредит цагийн үнэлгээ авсан. Уг сургалтын хувьд цаг үеэ олсон цаашид ажиллах чиг баримжаагаа тодорхойлсон, үр дүнтэй сургалт болсон.

Аймгийн мал эмнэлгийн газраас малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шөвөг яр, дотрын халдварт хордлого, цусан халдвартын вакциныг татан авч, хувийн мал эмнэлгийн малын эмч нарт захиалгыг үндэслэн хувиарлаж, дархлаажуулалтын ажил хийгдэж байна.

2024-05-28-нд аймгийн мал эмнэлгийн газраас малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг татан авсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдснээр 20 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөж, шинээр 8 иргэнд өндөр настны тэтгэврийг тогтоолоо. Эрүүл мэндийн даатгал цахим болсноор иргэд даатгуулагчдад шимтгэлээ цахимаар хэрхэн төлөх талаар 72 иргэнд зөвлөгөө өгсөн. Сайн дурын даатгалд 136 даатгуулагч даатгуулж тэдэнд цахимаар гэрээ хэрхэн хийх, шимтгэлээ төлөх талаар заавар зөвлөгөө өгс ажиллаж байна.

Улсын байцаагчид ирсэн өргөдөл-41, үүнээс						
Тэтгэвэр тогтоолгох	Өөрчлөн тогтоолгох	Банк солих	Тэтгэ мж	Ажилгүйдлы н тэтгэмж	Шийдвэрлэс эн	Үйлчилгээ авсан иргэн
8	20	2	10	1	41	305

Нийгмийн даатгалд хэрхэн хамрагдах талаар слагд бэлтгэн цахимд байршуулсан нь 700 гаруй даатгуулагчдад хүрсэн байна. Сумын нийгмийн даатгалын сангийн тайланг цахимаар гаргаж нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв. Нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан “Байцаагч ажилчдыг чадавхижуулах” сургалтад 2 хоног оролцлоо. Хүн эмнэлгийн 2022-2023 оны харилцахын баримтанд хяналт шалгалж хийж байна. Шинэ систем хэрэгжсэнтэй холбоотой 22 ажил олгогчийн нягтлангуудад тайланг хэрхэн тайлангнах талаар зөвлөн туслан тайлан хүлээн авч хамтран ажиллаж байна. Шинээр 2 ажил олгогчийг бүртгэн нийгмийн даатгалд хамруулав.

2023 оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Ногоон байгууламжийг будах, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх нийтийн хамарсан ажилд 10 иргэнийг 10 хоног ажиллуулж, мод

үржүүлгийн талбайд 108 нарс модыг тарьж суулгасан. Их Амгалан Хүрдэн хийдийн хашаан доторх хуучин модыг сэргээж, тарьц суулгах ажлыг зохион байгуулж 15 иргэнийг 10 хоног ажиллуулсан. 2024 оны өрхийг малжуулах төсөлд 15 иргэний баримт бичгийг хүлээн авсан.

Ерөнхий боловсролын сургууль :

- ✓ Ахмад багш М.Алтанцэцэг багшийн эзэмшсэн мэргэжлийн ур чадвар, туршлагаад тулгуурлан дотуур байрын багш болон үйлчилгээний ажилчдыг чадавхжуулах, дотуур байрын сурагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх, хүүхдийн оролцооны байгууллагын ажлыг идэвхжүүлэх зорилгоор “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” хүрээнд “Хайрын өргөө” төслийг 05 дугаар сарын 13-наас эхлэн сарын хугацаатай хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна




Дэлхийн аварга шалгаруулах өсвөр үеийн 100 буудалт даамны хос мөнгөн медальт Б.Энхмаа , мөнгө хүрэл медальт Б.Энхриймаа нарын нэрэмжит тэмцээн Дорноговь аймгийн Улаан -Уул суманд 2024 оны 5 дугаар сарын 18-19 өдрүүдэд болсон бөгөөд 7- 8 насны ангилалд Д.Ариунсолонго алт, 9-10 насны ангилалд Э.Ишгэрэл мөнгө, 11-13 насны ангилалд Ж.Мөнх-Амгалан хүрэл медаль авч амжилттай оролцлоо.



- ✓ 35 дахь Номын баярын өдрийг тохиолдуулан нутгийн яруу найрагч Т.Эрдэнэцогт 6-9 дүгээр ангийн сурагчидтай уулзаж чөлөөт ярилцлага зохион байгуулав. Яруу найрагч маань Японы сонгодог яруу найраг "ХАЙКУ" төрлийн талаар яриа таниулга хийж, өөрийн зохиосон ХАЙКУ шүлгээс уншиж сонирхуулав. Мөн хүүхдүүдэд "Зүүд" сэдэв өгч шүлэг зохиолгож өөрийн зохиосон номоор урамшуулсан сайхан арга хэмжээ боллоо. Нийгмийн ухааны багш Ц.Алтантүлхүүр "Зүүд" сэдвээр шүлэг бичиж сонирхуулав. 2024.05.17



- ✓ Онгон сумын ахмад багш нарын зөвлөл, Аймгийн нийтийн сангаас Номын баяр - 2024" арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан "Бидний номын тэмдэглэл" номын нүүр зураг бүтээх уралдаанд 9Б ангийн сурагч М.Урантуул "ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН ЭЗЭН"-ээр шалгарлаа.



- ✓ Хүүхдийн дуу хоолойг сонсох өдрийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр "Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв"-ийн 10 жилийн ойг угтаж хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн танилцуулга видеог 6-9-р ангийн сурагчдад мэдээллийг өглөө.
- ✓ "Сүхбаатарын Өнгө Сонин" -ний дугаарт "Хүрэл тулга- 2024" яруу найргийн наадамд сум, сургуулиа төлөөлөн амжилттай оролцсон 6б ангийн сурагч Г.Идэрмаагийн "Аавын хайр" шүлэг нийтлэгдсэн байна.



- ✓ Түвшинширээ сумын ИТХ-аас зохион байгуулсан Баруун бүсийн сумдын "U-14 volleyball"-ын тэмцээнд амжилттай оролцож 8аб ангийн хөвгүүдийн баг 3 дугаар байр эзлэв. Охид баг бас эн тэнцүүхэн өрсөлдлөө. Дасгалжуулагч багш Б.Нямцэрэн



- ✓ Уулбаян сумын Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн дарга С.Төмөрбаатар “Судар эгшиглэн 2024” төслийн заавал унших номын жагсаалтад орсон номноос худалдан авахад 612,300 мянган төгрөгийн хандив өгч ЕБС-ийн номын фондыг баяжууллаа.



Хүүхдийн цэцэрлэг:

- ✓ “Урлагийн наадам-2024” арга хэмжээг 5 төрлөөр зохион байгуулж 5 бүлгийн 136 хүүхдийг хамрууллаа.
- ✓ “Эрт илрүүлэг”-ийг сумын ЭМТ-тэй хамтран зохион байгуулж, 5 бүлгийн 142 хүүхдийг хамруулж, цэцэрлэгийн хэмжээнд нэгтгэн дүгнэлээ.

- ✓ Аймгийн багш ажилтны “Спортын наадам-2024”-т байгууллагаараа амжилттай оролцлоо.
- ✓ Ажлын байран дээр 1 удаагийн сургалтыг зохион байгуулж 19 багш, ажилтанг хамрууллаа.
- ✓ Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан Боловсролын ерөнхий хуулийн сургалтад эрхлэгч, 1 багш хамрагдлаа.
- ✓ 2 бэлтгэл бүлгийн 52 хүүхдийг сургуультай танилцуулах үйл ажиллагааг зохиолн байгууллаа.
- ✓ Соёлын төвөөс зарласан монгол бичгийн “Цэвэр бичигтэн шалгаруулах” уралдаанд 6 багш, ажилтан бичсэнээс багш М.Ариунзул 1-р байр, нярав Л.Сарангоо 2-р байр тус тус эзэллээ.
- ✓ 2023-2024 оны хичээлийн жилийн хаалтын үйл ажиллагаа “Тайлант өдөрлөг”-өө 05 дугаар сарын 28-ны өдөр хийхээр төлөвлөн ажиллаж байна.



Эрүүл мэндийн чиглэлээр:

- Нийт үзлэг- 1561
- Амбулаторын үзлэг- 660
- Гэрийн дуудлага – 277
- Алсын дуудлага- 128
- Хэвтэн эмчлүүлэгч – 148
- Өдрийн эмчилгээ – 17
- Хөнгөвчилсөн эмчилгээ-1
- Эхийн амрах байранд хэвтэн эмчлүүлэгч-5
- Артерийн даралт чихрийн шижингийн урьдчилан сэргийлэх үзлэг-219
- Хөхний эрт илрүүлэг үзлэг-96
- Гэрийн эмчилгээнд хамрагдсан -3
- Төрсөн эх-1
- 0-2 насны хүүхдийг товлотт дархлаажуулалтанд давхардсан тоогоор-180 бүрэн хамруулсан байна.
- 06-59 насны хүүхдийн А аминдэм-175
- 06-23 сартай хүүхдийн Олон найрлагат бичил тэжээл тараасан -68
- 0-5 насны хүүхдийн Д аминдэм -45
- Хэвтэн эмчлүүлэгчийг танин тодруулга- 68 -44
- Хурц үзүүртэй хог хаягдал-117,095
- Энгийн хог хаягдал-44,615
- Халдвартай хог хаягдал-73,682

- Шприц устгалын хатгалт нийт -1700 үүнээс хатгалтын тоо -3246, дундаж хатгалт-9,3, арьсан дотор-34 ,арьсан дор-107 Булчинд-254, Судсанд-2823

1.Хэвтэн эмчлүүлэгчийн танин тодруулагийн эрэмбийн ангилалыг – 114 хүнд хийсэн. Үүнээс нэн яаралтай(улаан)-1, яаралтай(цагаан) -68, яаралтай бус(ногоон)-1, хүлээгдэх боломжтой(цагаан)-44

Хагас жилд 25 удаагийн сургалтад давхартсан тоогоор 1010 хүн хамрагдсан байна.

1. Орчний эрүүл мэнд 2021он А/349
2. Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ 2022 он А/523
3. Хавдрын эсрэг арга хэмжээ 2021 он А/816
4. Элэг бүтэн монгол арга хэмжээ 2022 А/577
5. Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээ 2021 он А/780
6. Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээ 2021 А/559
7. Эх хүүхэд нөхөн үржихүйн арга хэмжээ 2021 А/760
8. Харшлаас сэргийлэх арга хэмжээ 2021 А/816
9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах баримтлах бодлогын арга хэмжээ 2021 А625
10. Эрүүл шүд арга хэмжээ 2024 он А572
11. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих арга хэмжээ 2024 он А321
12. Хүүхэд хамгаалал арга хэмжээ 2024 А147 зэрэг төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.

Соёлын төвийн чиглэлээр:

УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Ирсэн бичиг - 46
- Явсан бичиг - 03
 - Хариутай бичиг – 19
 - Хугацаандаа явсан бичиг – 19
 - Хугацаа болоогүй бичиг – 00
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 00

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1 “Цахим Соёл” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, дижитал шилжилтийг байгууллагад нэвтрүүлэх: ERP системийн ашиглан хүний нөөц, албан бичиг солилцох, цагийн бүртгэл, бланкуудын тохиргоо хийгдсэн.

1.2 Соёл олон нийтийн арга хэмжээг чанар хүртээмжтэй зохион байгуулах зорилгоор: “Монгол ардын нам”-ын гишүүд дэмжигчдийн шинэ жилийн цэнгүүн 12 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 130 хүн оролцсон байна.

1.3 Соёл, олон нийтийн арга хэмжээг чанар хүртээмжтэй зохион байгуулах зорилгоор: 12 сарын 23нд “Мөнгөн үдэш” шинэ жилийн цэнгүүн зохион байгуулж, урилгаар Жаахан шарга театрын дуучин Ш.Гэндэнсэнгэ, Жаахан шарга театрын гоцлол дуучин МУСТА А.Тодгэрэл нарыг урьж ард иргэдэд соёлын үйлчилгээг үзүүллээ. Нийт 178 хүн оролцсон байна.

1.4 Уулбаян сумын “Ахмадын” нэгдсэн шинэ жилийн цэнгүүн 12 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдаж, ардын авьяастанууд мандалъяийн

хөгжимөөр “попури” тоглож ард иргэддээ үзүүллээ. Нийт 78 ахмад цэнгүүнд оролцлоо.

1.5 12 дугаар сарын 26-нд Баялаг бүтээгчдэд зориулсан “Болор үдэш” цэнгүүн зохион байгуулагдаж, нийт 158 хүн оролцлоо.

1.6 “Уулбаяны залуус-2024” залуусын нэгдсэн шинэ жилийн цэнгүүн 12 сарын 29-ны өдөр зохион байгуулагдаж, Ардын авьяастанууд дуулж, Хөгжөөнт тоглоом, Үдшийн ханхүү, гүнж шалгаруулах ёслол, Азын сугалаа гэх мэт үйл ажиллагаа зохион байгууллаа.

1.7 “Гацуурхан” Сумын нэгдсэн шинэ жил 12 сарын 30 өдөр зохион байгуулагдаж, нийт 224 оролцсон байна. (Зураг1)

1.8 **“МОНГОЛ БИЧИГ УНШИХ ЦАГ”**- Монгол улсын ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25-р зарлиг, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2022 оны 01 дүгээр сарын 05 Засгийн газрын тогтоолын 5.3, 5.4, Сүхбаатар аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 01/70 тоотод заасныг тус тус үндэслэн **“ХОС БИЧИГТЭН”** болох зорилгын хүрээнд: Үндэсний Монгол бичиг унших цагтай боллоо. 7 хоног бүрийн Баасан гараг бүр хүмүүн бичиг сонин унших, монгол бичиг бичих цагтай болсон. Мөн байгууллагын цахим хаягт мэдээлэл оруулах болон тайлан мэдээнд Үндэсний бичгээ хэрэглэж хэвшиж байна. (Зураг2)

1.9 Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын хүрээнд: XVII-р жарны “Хилэнт эх” хэмээх “Модон луу” жилийн Сар шинийн хүндэтгэлийн битүүлэгний арга хэмжээнд зориулан хүндэтгэлийн тоглолтыг Сумын нийт иргэд, Ахмадууд, Улс, Аймаг, Сумын аварга малчид, уяачиддаа 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Тоглолтонд нийт 11 хүн оролцсоноос Ардын авьяастанууд, Б.Туяа, Н.Лувсанцэрэн, болон дугуйлангийн сурагчид оролцлоо. Тоглолтыг нийт 203 хүн үзэж сонирхсон байна. (Зураг3)

1.10 Хүүхдүүдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор: 5-9-р ангийн сурагчдын дунд 3 дугаар сарын 05-ны өдөр “OPEN MIC” арга хэмжээг зохион явуулсан. Тэмцээнд 13 хүүхэд оролцож, 59 хүүхэд үзэж сонирхлоо. (Зураг4)

1.11 Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн ард иргэдийг соён гэгээрүүлэх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор: “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах” өдөрт зориулсан хөтөлбөрт үдшийн цэнгүүнийг 3 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Үдшийн цэнгүүнд 187 хүн хүрэлцэн ирж үзлээ. (Зураг5)

1.12 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон цэцэрлэгийн насны хүүхдүүдэд урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох Монгол эстрад дууны урын санг баяжуулах, Хүүхэд багачуудад дуулах ур чадвар олгох, урлагийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэх, ирээдүйн эстрадын авьяаслаг дуучдыг тодруулах зорилгоор: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би эстрадын дуучин” 1 дүгээр шатыг 3 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Нийт 53 хүүхэд оролцсоноос: Цэцэрлэгийн насны ангилалд

1-р байр Б.Ариунбаатар

2-р байр И.Нандинхүсэл

3-р байр Г.Сондор нар тус тус шалгарлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 6-11 насны ангилалд:

1-р байр Б.Мишээл

2-р байр А.Эмүжин

Ерөнхий боловсролын сургуулийн 12-15 насны ангилалд:

1-р байр М.Энх-Учрал

2-р байр М.Номинзаяа

3-р байр Б.Төгс-Уянга тус тус шалгарлаа. (Зураг6)

1.13 Нийтээр тэмдэглэх баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, ард иргэдийг урлагаар дамжуулан соён гэгээрүүлэх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор: Эр цэргийн баярт зориулж, Хөтөлбөрт үдшийн цэнгүүн зохион байгууллаа. Цэнгүүнд нийт 173 хүн оролцлоо. (Зураг7)

1.14 5 дугаар сарын 03-нд Хүүхдийн цэцэрлэгтэй хамтран “Урлагийн баяр-2024” уралдаан тэмцээнийг

-Шүлэг

-Найрал дуу

-Гоцлол дуу

-Хамтлаг бүжиг

-Хамтлаг дуу гэсэн 5 төрлөөр зохион байгууллаа. (Зураг8)

1.15 Соёл олон нийтийн арга хэмжээг чанар хүртээмжтэй зохион байгуулах зорилгоор: Татвар төлөгчдөд зориулсан нийтийн бүжиг зохион байгууллаа. Нийт 48 хүн оролцсон.

1.16 Хүүхэд багачуудад соёлын боловсрол олгох, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор: Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын Гэгээн Муза-17 Хүүхдийн оролцоот жүжгийн төрлөөр оролцож, цомын эзэн болсон авьяаслаг сурагчдын тоглосон “Тэрх нуурын дэгдээхэй” мюзикл жүжиг тоглогдлоо. 93 хүүхэд,багачууд үзэж сонирхсон. (Зураг9)

1.17 Соёлын боловсрол олгох, цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор: 5 дугаар сарын 12-нд Ахмадын холбоотой хамтран “**ДУУЛАХ ӨДӨР**” дуун цэнгүүнийг зохион байгуулж “Дартс”, Хөзрийн тэмцээн зохион явууллаа. Нийт 88 ахмад оролцлоо. (Зураг10)

1.18 5 дугаар сарын 17 өдөр 1992 оны төгсөлтийн нэрэмжит бүжиг зохион байгууллаа. Үдэшлэгт 58 насанд хүрэгсэд хамрагдлаа.

1.19 Соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор: 2 дахь жилдээ 7 хоног бүрийн 3 дахь өдрийн 14 цагт Дасгал хөдөлгөөн болон стандарт 16 бүжгийг тогтмол явуулж байна. (Зураг11)

1.20 Уулбаян сумын “ОРЛОЙН ТҮМЭН ЭХ” уяачдын холбоо, МҮМУУХ-ны нарийн бичиг М.Ариунболд, МУ-ын алдарт уяач Базаргарьд нартай хамтран уяачдын хурал зөвлөгөөнийг 05 сарын 18-нд зохион байгуулсан. Сүхбаатар аймгийн брэнд бол хурдан адуу юм. Сүүлийн жилүүдэд эрлийз адуу гарснаар Монгол үйлдвэрийн адуу аажмаар эрлийз болох цаашлаад Сүхбаатарын брэнд гэгдэх адуу үгүй болох эрсдэлтэй байдалд хүрээд байна. Үүнийг хэрхэн даван туулах ямар арга хэмжээ зохион байгуулах тал дээр зөвлөгөө болон харилцан яриа өрнүүлж, Монгол адууны уралдааныг зөвхөн Монгол адуунд **чип** суулган уралдахаар болсон. Хуралд нийт 69 уяач суусан байна. Хурал Засаг дарга

Д.Амартайван, ИТХ-ын дарга Р.Анхбаяр, Нутгийн зөвлөлийн дарга С.Төмөрбаатар, Монголын үндэсний радио телевизийн найруулагч Т.Батбаатар нар оролцсон. Мөн уяачдын төлөөл үндэсний телевизид ярилцага өгч цаашид Монгол адуугаа хэвээр нь хадаглах авч үлдэх талаар ярилцсан. (Зураг12)

1.23 **“АЗ ЖАРГАЛТАЙ ХҮҮХЭД НАС”** хүүхдийн баярын нэгдсэн үйл ажиллагааг хүүхдийн эрхийг хамгаалах өдөр зохион явуулсан. Хүүхдийн баярын арга хэмжээний нэгдсэн хөтөлбөрийг боловсруулж сумын төсөвт байгууллагыг уриалан оролцуулж бүтэн өдрийн турш хүүхдийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Тоглолтонд 30 гаруй хүүхэд оролцлоо. (Зураг13)

1.24 Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Мөлхөө жаал” тэмцээнийг бяцхан хүүхэд багачуудын дунд зохиож тэмцээнд оролцсон бүх хүүхдүүдэд гарын бэлэг гардууллаа.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2.1 Шинэ жилийн өөрийн орлого 3.328000 төгрөг төвлөрүүлсэн байна.

2.2 Хөгжмийн өрөө болон хүүхдийн өрөөг тохижууллаа. Хөгжмийн өрөөний тохижилтын ажлыг гэрээт ажилтан С.Гансүх, Хөгжмийн багш О.Эрдэнэбаатар, хүүхдийн өрөөний тохижилтын ажилд ЕБС-ийн 6 хүүхэдтэй хамтран тохижилтыг ажлыг хийж дуусгалаа. (Зураг14,15)

2.3 Өөрийн орлогоос: “Би эстрадын дуучин” тэмцээнд 115000 (Нэг зуун арван таван мянган) төгрөгөөр шагналаа.

2.4 “Хүрэл тулга” тэмцээнд: 50.000 (тавин мянган) төгрөгөөр шагнав.

2.5 “Цолгүй Залуу бөхчүүдийн барилдаанд: 310.000 (Гурван зуун арван мянган) төгрөгөөр шагналаа.

2.6 Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 60 сая төгрөг тавьж өгсөн. Үүний хүрээнд лед дэлгэц (4х6), урлагийн хувцасны тендер зарлаж лед дэлгэцийн ажилд “Сити лед” компани шалгарч 05 сарын 31-ны өдөр хүлээлгэн өгсөн. (Зураг 16)

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1 Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд 1,000,000 төгрөгний 37 нэр төрлийн 47 ширхэг номоор баяжилт хийгдэж шинэ номын үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнг нийт 23 хүн үзэж сонирхлоо. (Зураг17)

3.2 Д.Сүхбаатар Жанжин мэндлэсний 131-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, түүний баатарлаг үйл хэргийг сурталчлан таниулах, ирээдүй хойчид эх оронч үзэл, Монгол бахархалыг төлөвшүүлэх зорилгоор: Миний мэдэх Д.Сүхбаатар гар зургийн уралдаан зохион байгуулж нийт 15 хүүхэд оролцсоноос И.Энхжин тэргүүн байр, С.Сарнай дэд байр эзэлж дурсамж, мөнгөн шагналаар шагнав. (Зураг18)

3.3 Их Жанжин Д.Сүхбаатарын мэндлэсний 131 жилийн ойг тохиолдуулан: ЖАНЖИН Д.СҮХБААТАР 2024-цахим зургийн уралдаан зохион байгуулж нийт 11 хүүхэд оролцож, 1-р байр У.Ивээлт-од, 2-р байр Б.Батэрдэнэ нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа. (Зураг19)

3.4 3 дугаар сарын 07-нд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, монгол хэлний уран яруу баялаг үгийн сантай танилцуулах, өөрийгөө илэрхийлэх хайртай дотнын хүндээ чин сэтгэлийн үгээ

дамжуулах зорилгоор “Сэтгэлийн үгээ дайгаарай” захидлын уралдаан зарлаж шилдэг захидлуудыг шалгарууллаа. Нийт 31 хүүхэд захидлаа ирүүллээ. (Зураг20)

Шилдэг захидал: Ө.Мөнхчимэг

Шилдэг захидал: И.Энхжин

Шилдэг захидал: Н.Өсөхбаяр

3.5 Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Л.Дашбалжинням хууль эрх зүйн мэргэжлийн холбогдолтой 15 ширхэг ном, гарын авлага Нийтийн номын санд хандивлалаа.

3.6 Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан, Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд хүүхэд багачуудыг Монгол хэл үсгийн урлагийн гайхамшигт ертөнцөөр аялуулан, үг хэллэгийн арвин баялаг сантай танилцуулж, сэтгэн бодох болон өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх, зохиох бүтээх туурвих урлагт сургах зорилгоор: Өсвөрийн яруу найрагчдын “Хүрэл тулга-2024” уралдааны 1 дүгээр шатыг 3 дугаар сарын 21-нд зохион байгууллаа. Нийт 9 сурагч оролцож,

1-р байр Г.Идэрмаа

2-р байр С.Эрдэнэмөнх тус тус шалгарлаа. (Зураг21)

3.7 “ЗОХИОЛЧ, УНШИГЧИДЫН УУЛЗАЛТ” Уулбаян сумын харьяат яруу найрагч Т.Эрдэнэцогтийн “ЗОХИОЛЧ, УНШИГЧИДТАЙ ХИЙХ УУЛЗАЛТ”-ийг 5 дугаар сарын 16-нд зохион байгууллаа. Уулзалтад: Яруу найрагч Т.Эрдэнэцогт, Соёл, Урлагийн газрын дарга Б.Золхүү, Хэлтсийн дарга Ч.Осгонбат, Нутгийн зөвлөлийн дарга Д.Төмөрбаатар, дэд дарга Т.Батбаатар, МЗЭ-ийн Сүхбаатар аймгийн салбарын төлөөлөл яруу найрагч У.Буд, Ж.Өлзийбат, нутгийн найрагч ахмад настан Даваа гуай, ахмад номын санч МУСТА С.Дуламсүрэн, ахмад номын санч МУСТА П.Ганцэцэг, Хүрэл тулга – 2024 уралдааны оролцогчид, ЕБС-ын багш нар, шүлэг яруу найраг сонирхогч хүүхдүүд оролцлоо. Нийт 135 хүүхэд багачууд уулзалт, үзэсгэлэнд хамрагдлаа. (Зураг22)

3.8 Номын баярын үзэсгэлэнд ЕБС-ын сурагчдын уншсан номын тэмдэглэл, номын бүтээлийн үзэсгэлэн, Ж.Мөнх-Од багштай 2б ангийн сурагчид, Э.Шинэтуяа багштай 2а ангийн сурагчид, Л.Мөнхтуяа багштай 9а ангийн сурагчид, Соёлын төвийн Нийтийн номын сангийн дэргэдэх “Тунгаамал” номын клубын сурагчид, Уулбаян сумын Жаргалант багийн иргэн Даваагийн Ганбаатарын цуглуулга буюу 70 гаруй морины тухай ном, сонин, сэтгүүлийг нийтэд дэлгэж олны хүртээл болголоо. Үзэсгэлэнд нийт 70 гаруй сурагчдын 30 гаруй бүтээл дэлгэгдлээ. (Зураг23)

3.9 “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД – 2024 ” Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийг тохиолдуулан ЕБС-ын 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд “Уншихын аварга” шалгаруулах тэмцээн зохион явууллаа. Тэмцээнд 9 сурагч оролцсоноос эхний 3 байрыг шалгаруулж шагнаж урамшууллаа. (Зураг24)

1-р байранд: Т.Энгүнлянхуа (9б анги)

2-р байранд: А.Магалжав (9б анги)

3-р байранд: Б.Батцэцэг (9б)

3.10 Албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн дунд Үндэсний бичгийн “Цэвэр бичигтэн” шалгаруулах тэмцээн буюу Уулбаян сумын дуу болох “Тэнгэрээс

буусан хүлэг уул” дууг хэн цэвэр бичих вэ? тэмцээнд нийт 10 хүн оролцсоноос эхний 2 байрыг шалгаруулж шагнаж урамшууллаа. (Зураг25)

1-р байранд: С.Ариунзул (Хүүхдийн цэцэрлэгийн бүлгийн багш)

2-р байранд: Л.Сарангоо (Хүүхдийн цэцэрлэгийн нярав)

3.11 “АХМАДЫН ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ” Нийгмийн халамжийн газраас явуулдаг “Ахмадын зөвлөн туслах үйлчилгээ”-г ахмад номын санч МУСТА С.Дуламсүрэнгээс сургалтыг авч дугуйлангийн сурагчид болон соёлын төвийн албан хаагчдад зөвлөн туслахаар ажиллаа. (Зураг26)

3.12 “СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА” Нийтийн номын сангаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Сэтгэл ханамжийн судалгаанд нийт 56 хүүхэд, 33 насанд хүрэгч хамрагдлаа. (Зураг27)

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1 Сүм хийдэд хадгалагдаж байгаа хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжууллаа. Нийт 26 эд зүйлс бүртгэсэний 23-ийг шинээр бүртгэж авлаа. (Зураг28)

4.2 Үндэсний өв соёлын түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, залуучуудын чөлөөт цагыг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор: “Эр цэргийн баярт” зориулж цолгүй залуу бөхчүүдийн барилдаан зохион байгууллаа. Нийт 20 залуу бөх оролцлоо. Мөн 06 сарын 01 4-6 дугаар ангийн сурагчдын дунд хүчит бөхийн барилдааныг зохион явуулсан. (Зураг28)

4.3 Соёлын төвөөс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ДӨРВӨН БЭРХ” шагайн наадгай тэмцээнийг 3 төрлөөр зохион явуулж 8 багийн 24 хүн оролцож эхний гурван байрыг шагнаж урамшууллаа. (Зураг 29)

4.4 Сүхбаатар аймгийн BBS телевизийн “СОД ӨВ” нэвтрүүлэгт өвлөн уламжлагч Б.Дэнсмаа, Н.Лувсанцэрэн нар оролцлоо.

4.5 СҮХБААТАР АЙМГИЙН АХМАДЫН НУМТ ХАРВААНЫ холбооны нэрэмжит тэмцээн Уулбаян суманд зохион байгуулагдаж байна. Уг тэмцээнд Сүхбаатар аймгийн 13 сумаас нийт 20 багийн 100 гаруй ахмадууд ирж оролцсон өргөн дэлгэр тэмцээн боллоо. (Зураг 30)

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1 Хүүхэд бүрийн авьяасыг бүх талаар нь хөгжүүлэх, өөрийгөө танин мэдэх, амжилтад хүрэх суурийг тавих, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох, тэднийг урлаг, спортын мэдрэмжээр дамжуулан хүний амьдралын сайхан, утга учрыг хамт олноороо мэдрэх, өөрөөрөө болон найз нөхдөөрөө бахархах хувь хүний зан чанарыг төлөвшүүлэх зорилгоор: “**МОРИН ХУУРЫН**” дугуйлан 7 хоног бүрийн 1 дэх, 5 дахь өдөр хичээллүүлж, 2 хүүхэд хамрагдаж байна. (Зураг31)

5.2 ЕБС-тай хамтран 7 хоног бүрийн 3 дахь өдөр “**ВОЛЕЙБОЛЫН**” дугуйлан хичээллүүлж байна. Нийт 16 хүүхэд хамрагдаж байна.

5.3 Хөгжимд дур сонирхолтой болгох, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, ардын хөгжмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор: “**ЛИМБЭ**” хөгжмийн дугуйланг 7 хоног бүрийн 2 дахь өдөр хичээллүүлж 2 хүүхэд хамрагдаж байна. (Зураг32)

5.4 Номын сангийн дэргэдэх “ЯРУУ - ЭГШИГ” уран уншигчийн дугуйланд 18 сурагч хамрагдаж байна. (Зураг 33)

ЗУРГАА: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:

6.1 Соёлын сэргэлт-2024 аяны хүрээнд соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд 21 аймгийн соёл, урлагийн газар, Соёлын яамны харьяа байгууллагын удирдлагууд оролцож, өнгөрсөн хугацаанд соёлын салбарт хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал зөвлөмжөө хуваалцсан. Мөн морин хуурын анхдугаар чуулганд оролцсон. (Зураг34)

ДОЛОО: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

7.1 Соёлын төвийн тохижилтыг сайжруулах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор: Кассны өрөөнд өлгүүр хийж тохижууллаа.

7.2 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4, Сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/201 дүгээр захирамжийн дагуу “Эд хөрөнгийн тооллогыг 12 сарын 25-26 өдрүүдэд хийж дуусгалаа.

7.3 УИХ-ийн гишүүн Н.Ганибал, Ж.Батсуурь болон УИХ дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөхүүд: Ирэх жилүүдэд бүс нутгийн хөгжилд дэд бүтэц, авто зам, төмөр зам том бодлогын асуудал руу орох тухай ард иргэддээ мэдээлэл хүргэж санал солилцлоо.

7.4 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 31 дүгээр зүйлийн 31.1, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын засаг даргын А/65 захирамжийн хүрээнд: 60ш хайлаас тарилаа. (Зураг35)

НАЙМ: СУРГАЛТУУД:

8.1 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Соёлын өвийн үндэсний төв: Хөдлөх дурсгал зүйл, СББӨ, ТСҮХД-ийн “тоон дүн мэдээ” хэрхэн авах нэгтгэх сургалтанд хамрагдсан.

8.2 Хүний нөөцийг бэлтгэх, сургах, нийгмийн баталгааг хангах зорилгоор: **МУСУИС-аас** зохион байгуулж байгаа “Номын сангийн үндэс” кредит тооцох цахим сургалтанд номын санч хамрагдсан.

8.3 “ЦАХИМ СОЁЛ” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын систем хариуцсан админ, бичиг хэргийн ажилтануудад зориулсан сургалтанд хамрагдлаа.

8.4 3 дугаар сарын 14-нд Соёлын салбарын бүх шатны байгууллагуудад дотоод хяналт шалгалтыг төлөвшүүлэх сургалтад хамрагдлаа.

8.5 “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах эрхийг хамгаалах журам”-ын танилцуулга хийх сургалтад хамрагдлаа.

8.6 05 сарын 16-нд Төрийн албаны шинэчлэл, төрийн албан хаагчийн цалин, хөлс, нийгмийн баталгаа сэдвээр зохион байгуулагдлаа.

8.7 Удирдлагын академийн “Монгол бичгийн” сургалтад бүх ажилтад хамрагдан мэдлэгээ дээшлүүлж байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ